



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийцэл өрхийн эрүүл мэндийн төвийн ЗГБХН-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/3/НА-СТА-БСД

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор: В.Жавзмаа
Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГБХН	Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.03.15 № 104

танай _____-ны № _____-т

“НИЙЦЭЛ” ӨРХИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЗГБХН-ИЙН
ДАРГА Г.БОЛОРМАА ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв ЗГБХН-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв ЗГБХН нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Харилцахын зарлагын гүйлгээ хийхдээ цахим төлбөрийн е-баримтгүй, анхан шатны баримтын бүрдлийг хангуулаагүй, хөтөлбөл зохих анхан шатны баримтуудыг хөтлөөгүй, авлага, өр төлбөр үүсгэсэн, дотоод хяналт хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл

D:\my doc\alban bichig\ 2022-A4.doc

ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягт нөхөх заавар"-ын хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцэхгүй, аудитын оршин байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв ЗГБХН-ийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагнал, толилуулга, тодруулгууд нь УСНББОУС-ын дагуу илэрхийлж, Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн гүйцэтгэлийг тайлагнадаг. Улсын бүртгэлд зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэж бүртгүүлсэн, ашгийн төлөө байгууллага байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гүйцэтгэлийн гэрээгээр Орхон аймгийн Баян-Өндөр сумын Цагаанчулуут, Булаг, Баянбулаг багийн 12,100 иргэнд 292,603.0 мянган төгрөгийн санхүүжилтээр төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх болсон байна. Гэрээний хэрэгжилтийг 87.7 хувьтай биелүүлж, хангалттай үнэлгээ авсан байна. Мөн хавдрын илрүүлэг үзлэгийг 2.5-7.0 хувиар өсгөжээ.

Аймгийн Санхүү хяналт, аудитын албанаас 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар тус өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагааг хангалттай бус гэж дүгнэжээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,104,425.94</u>	<u>76,905,730.43</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	154,189.69	255,582.43
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	154,189.69	255,582.43
3121	Төгрөг	154,189.69	255,582.43
31213	Арилжааны банк дахь харилцах	154,189.69	255,582.43
33	АВЛАГА	338,790.00	65,361,690.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	338,790.00	1,273,190.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	62,088,500.00
335	Бусад авлага	-	2,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	2,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8,611,446.25	11,288,458.00
351	Түүхий эд материал	7,467,152.25	10,733,458.00
35110	Тусгай зориулалттай материал	2,285,500.00	5,238,400.00
35130	Эм боох материал	5,181,652.25	5,495,058.00
354	Хангамжийн материал	1,144,294.00	555,000.00
35410	Бичиг хэргийн материал	424,900.00	555,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>37,100,069.20</u>	<u>216,470,309.94</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	37,100,069.20	216,470,309.94
392	Биет хөрөнгө	36,856,319.25	216,275,310.02
39203	Авто-тээврийн хэрэгсэл	22,000,000.00	48,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(22,000,000.00)	(22,650,000.01)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	77,514,500.00	207,159,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(52,367,671.61)	(56,519,444.15)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,593,749.00	50,034,739.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,884,258.14)	(9,749,884.82)
393	Биет бус хөрөнгө	243,749.95	194,999.92
39303	Бусад биет бус хөрөнгө	325,000.00	325,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(81,250.05)	(130,000.08)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>46,204,495.14</u>	<u>293,376,040.37</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,589,351.02</u>	<u>29,470,107.29</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,589,351.02	29,470,107.29
413	Өглөг	2,589,351.02	29,470,107.29
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,589,351.02	4,331,742.97
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	9,327,233.32
4136	Бусад өглөг	-	15,811,131.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	13,757,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	2,054,131.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>43,615,144.12</u>	<u>263,905,933.08</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	43,615,144.12	263,905,933.08
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	43,138,450.00	43,138,450.00
51101	Өмч: - төрийн	43,138,450.00	43,138,450.00
512	Хуримтлагдсан үр дүн	(2,042,405.88)	218,248,383.08
51210	Өмнөх үеийн үр дүн	(2,042,405.88)	(2,042,405.88)
51220	Тайлант үеийн үр дүн	-	220,290,788.96
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,519,100.00	2,519,100.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>46,204,495.14</u>	<u>293,376,040.37</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	308,527,653.84	753,967,740.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,260,260.84	241,005,211.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,063,160.84	78,751,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,063,160.84	16,663,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	16,663,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,063,160.84	
120009	Бусад орлого	-	62,088,500.00
122	Тусламжийн орлого	4,197,100.00	162,253,711.00
122001	Хандив тусламж /дотоод/	4,197,100.00	162,253,711.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	303,267,393.00	512,962,529.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	269,938,363.00	292,603,036.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	269,938,363.00	292,603,036.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	829,900.00	6,505,193.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,805,193.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	829,900.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	32,499,130.00	213,854,300.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	32,499,130.00	213,854,300.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	293,641,834.62	533,676,951.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	293,641,834.62	533,676,951.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	285,728,913.64	517,514,297.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	207,558,973.00	261,267,637.00
210101	Үндсэн цалин	157,830,098.00	190,682,794.00
210102	Нэмэгдэл	38,864,436.00	67,448,549.00
210104	Урамшуулал	10,864,439.00	3,136,294.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,230,851.89	28,712,870.46
210201	Тэтгэврийн даатгал	6,841,569.76	21,671,381.91
210202	Тэтгэмжийн даатгал	459,982.50	1,474,710.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	364,625.99	-
210204	Ажилгүйдлийн даатгал	77,188.52	1,126,312.55
210205	Эрүүл мэндийн даатгал	3,487,485.12	4,440,465.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,418,046.81	7,031,859.17
210301	Гэрэл, цахилгаан	920,899.28	847,965.77
210302	Түлш, халаалт	1,497,147.53	6,183,893.40
2104	Хангамж, бараа материалын зардал	15,612,454.00	14,781,134.90

Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв ЗГБХН-ийн 2021 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	7,326,306.00	4,801,651.00
210402	Тээвэр, шатахуун	3,760,500.00	4,340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	837,658.00	1,105,300.90
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	702,000.00	675,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,985,990.00	3,444,483.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	414,700.00
2105	Нормативт зардал	35,334,730.58	183,987,220.25
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,550,830.58	176,309,133.75
210502	Хоол, хүнс	4,567,000.00	5,880,586.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,216,900.00	1,797,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	725,000.00	2,426,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	725,000.00	-
210604	Урсгал засвар	-	2,426,000.00
2107	Томилолт, зочны зардал	353,600.00	128,000.00
210702	Дотоод албан томилолт	353,600.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	128,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,685,735.00	10,284,148.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,280,375.00	9,556,548.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	83,160.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,500.00	224,060.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	57,600.00	200,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	203,540.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	795,100.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,809,522.36	8,895,427.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,491,350.00	1,209,278.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	669,692.00	970,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,648,480.36	6,716,149.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,912,920.98	16,162,654.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,807,601.00	16,162,654.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	175,190.00	322,924.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,794,661.00	6,258,000.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	-	110,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,837,750.00	9,471,730.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	105,319.98	-
213304	Хөрөнгийн	105,319.98	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>14,885,819.22</u>	<u>220,290,788.96</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>14,885,819.22</u>	<u>220,290,788.96</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	43,138,450.00	2,519,100.00	(17,208,735.08)	28,448,814.92
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	43,138,450.00	2,519,100.00	(17,208,735.08)	28,448,814.92
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			15,166,329.20	15,166,329.20
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	43,138,450.00	2,519,100.00	(2,042,405.88)	43,615,144.12
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	43,138,450.00	2,519,100.00	(2,042,405.88)	43,615,144.12
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	43,138,450.00	2,519,100.00	(2,042,405.88)	43,615,144.12
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
Тайлант үеийн үр дүн			220,290,788.96	220,290,788.96
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	43,138,450.00	2,519,100.00	218,248,383.08	263,905,933.08

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>305,691,927.00</u>	<u>534,830,146.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	16,663,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	16,663,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	16,663,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	16,663,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	305,691,927.00	518,167,146.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	269,938,363.00	292,603,036.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	269,938,363.00	292,603,036.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	829,900.00	6,505,193.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,805,193.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	829,900.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	34,923,664.00	219,058,917.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,424,534.00	5,204,617.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	32,499,130.00	213,854,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>293,661,902.68</u>	<u>482,828,363.26</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	293,661,902.68	482,828,363.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	283,604,957.68	463,515,223.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	205,308,411.98	277,011,671.19
210101	Үндсэн цалин	205,308,411.98	277,011,671.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,230,851.89	12,160,844.32
210201	Тэтгэврийн даатгал	6,841,569.76	10,325,577.82
210202	Тэтгэмжийн даатгал	459,982.50	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	364,625.99	-
210204	Ажилгүйдлийн даатгал	77,188.52	-
210205	Эрүүл мэндийн даатгал	3,487,485.12	1,835,266.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,418,046.81	5,071,361.35
210301	Гэрэл, цахилгаан	920,899.28	847,965.77
210302	Түлш, халаалт	1,497,147.53	4,223,395.58
2104	Хангамж, бараа материалын зардал	14,993,148.00	16,725,370.90
210401	Бичиг хэрэг	5,528,506.00	4,843,701.00
210402	Тээвэр, шатахуун	3,560,500.00	4,240,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	837,658.00	1,105,300.90
210404	Ном, хэвлэл	100,000.00	25,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	582,000.00	675,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,384,484.00	5,836,369.00
2105	Нормативт зардал	40,189,422.00	136,461,329.50

Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв ЗГБХН-ийн 2021 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33,114,622.00	129,416,243.00
210502	Хоол, хүнс	4,857,900.00	5,610,086.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,216,900.00	1,435,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	610,000.00	3,505,120.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	610,000.00	-
210604	Урсгал засвар	-	3,505,120.00
2107	Томилолт, зочны зардал	353,600.00	89,000.00
210702	Дотоод албан томилолт	353,600.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	89,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,726,435.00	10,329,148.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,914,675.00	9,601,548.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	83,160.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,500.00	224,060.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	31,800.00	200,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	203,540.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,227,300.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,775,042.00	2,161,378.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,105,350.00	1,191,378.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	669,692.00	970,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,056,945.00	19,313,140.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,056,945.00	19,313,140.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,424,534.00	5,736,410.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,794,661.00	3,995,000.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	-	110,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,837,750.00	9,471,730.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>12,030,024.32</u>	<u>52,001,782.74</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,908,900.00	51,900,390.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,908,900.00	51,900,390.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,908,900.00	51,900,390.00
222001	Тоног төхөөрөмж	2,299,900.00	
223001	Бусад хөрөнгө	9,609,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	51,900,390.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(11,908,900.00)</u>	<u>(51,900,390.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	121,124.32	101,392.74
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		154,189.69
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	154,189.69	255,582.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	292,603,036.00	534,728,753.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	292,603,036.00	482,828,363.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	286,954,996.00	463,515,223.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	205,308,412.00	277,011,671.00
210101	Үндсэн цалин	205,308,412.00	277,011,671.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,230,860.00	12,160,844.32
210201	Тэтгэврийн даатгал	11,230,860.00	10,325,577.82
210205	Эрүүл мэндийн даатгал		1,835,266.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,418,046.00	5,071,361.35
210301	Гэрэл, цахилгаан	2,418,046.00	847,965.77
210302	Түлш, халаалт		4,223,395.58
2104	Хангамж, бараа материалын зардал	14,993,150.00	16,725,370.90
210401	Бичиг хэрэг	14,993,150.00	4,843,701.00
210402	Тээвэр, шатахуун		4,240,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,105,300.90
210404	Ном, хэвлэл		25,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		675,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		5,836,369.00
2105	Нормативт зардал	40,539,450.00	136,461,329.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,539,450.00	129,416,243.00
210502	Хоол, хүнс		5,610,086.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,435,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,610,000.00	3,505,120.00
210604	Урсгал засвар		3,505,120.00
2107	Томилолт, зочны зардал	353,600.00	89,000.00
210702	Дотоод албан томилолт	353,600.00	89,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,726,435.00	10,329,148.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,726,435.00	9,601,548.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		224,060.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		200,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		203,540.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,775,043.00	2,161,378.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,775,043.00	1,191,378.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		970,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,648,040.00	19,313,140.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,648,040.00	19,313,140.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		5,736,410.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,810,240.00	3,995,000.00

Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв ЗГБХН-ийн 2021 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		110,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,837,800.00	9,471,730.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	51,900,390.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	51,900,390.00
223001	Бусад хөрөнгө		51,900,390.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	292,603,036.00	534,830,146.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	292,603,036.00	292,603,036.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	292,603,036.00	292,603,036.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	6,505,193.00
132001	Орон нутгийн төсвөөс		6,505,193.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	219,058,917.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	5,204,617.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	213,854,300.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	16,663,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		16,663,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	154,189.69	154,189.69
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		255,582.43

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийцэл өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор В.Жавзмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хууль, өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрэмд заасны дагуу үйлчлэх хүрээний хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх чиг үүрэг бүхий, сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод хяналт, аудит хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлого 532,728.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,539.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,277.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 247,171.5 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	151.2	255.6	101.4
Авлага	338.8	65,361.7	65,022.9
Бараа материал	8,611.4	11,288.4	2,677.0
Үндсэн хөрөнгө	37,100.1	216,470.3	179,370.2
Нийт хөрөнгө	46,204.5	293,376.0	247,171.5
Өр төлбөр	2,589.4	29,470.1	26,880.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	43,615.1	263,905.9	220,290.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	46,204.5	293,376.0	247,171.5

Мөнгөн хөрөнгийн данс 255.6 мянган төгрөг болж 101.4 мянган төгрөгөөр өсжээ.

Авлагын данс 65,361.7 мянган төгрөг болж 65,022.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь эрүүл мэндийн даатгалын сангаас авах үйлчилгээний төлбөр, цалингийн болон тоног төхөөрөмжийн урьдчилгаанаас шалтгаалсан байна.

Бараа материалын данс 11,288.4 мянган төгрөг болж 2,677.0 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалын худалдан авалтаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 216,470.3 мянган төгрөг болж 179,370.2 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 122,461.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн авч, өөрийн орлогоос 63,625.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, автомашин зэргийг худалдан авснаас шалтгаалжээ.

Өр төлбөрийн данс 29,470.1 мянган төгрөг болж 26,880.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь эм, байр ашиглалтын зардал болон автомашин худалдан авсан, татварын тооцооноос үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 263,905.9 мянган төгрөг болж 220,290.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Нийцэл өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 445,440.1 мянган төгрөгөөр буюу 144.3 хувиар, нийт зардал өмнөх оноос 240,035.1 мянган төгрөгөөр буюу 81.7 хувиар өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв нь Булаг багийн 3,350, Баянбулаг багийн 3,290, Цагаанчулуут багийн 5,850, нийт 12,490 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэхээр 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 293,603.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 293,603.0 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна. Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг өөрчлөөгүй баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв нь тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх эрүүл мэнд төсөл, хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгай зориулалтын шилжүүлгээр 292,603.0 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 213,854.3 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 16,663.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын төсөл, хөтөлбөрийн зардлаас 6,505.1 мянган төгрөг, НД-ын сангаас 5,204.7 мянган төгрөг, нийт 534,830.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, 534,728.8 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт төсвийн санхүүжилтийн данс ашигладаггүй болно.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

Орхон аймгийн онцгой байдлын комиссын 2021 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 732 тоот, Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын мөн өдрийн 01/436 тоот албан бичгүүдэд үндэслэн эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээс 30% буюу 7,800.0 мянган төгрөгийн урьдчилгаа төлж, автомашин худалдан авсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв ЗГБХН-ийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагнал, толилуулга, тодруулгууд нь УСНББОУС-ын дагуу илэрхийлж, Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн гүйцэтгэлийг тайлагнадаг. Гэтэл өрхийн эрүүл мэндийн төв нь улсын бүртгэлд зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэж бүртгүүлсэн, ашгийн төлөө байгууллага бөгөөд энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34-т "төсвийн байгууллага гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн

этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг” гэж заасантай нийцээгүй нь анхаарах ёстой асуудал гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст улирал бүр мэдээллийг ил тод байршуулахаас 2, 3 улирлын мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, зарлагын гүйлгээ хийхдээ цахим төлбөрийн е-баримтгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, хөтөлбөл зохих анхан шатны баримтуудыг хөтлөөгүй, авлага, өр төлбөр үүсгэж ажиллажээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягт нөхөх заавар"-ын хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцэхгүй, аудитын оршин байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Мөн тус өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийж, шалгалтаар нийт 100,046.1 мянган төгрөгийн зөрчил илэрч, 354.3 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага, 99,619.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 8 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 1,040.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 2,440.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 7,550.0 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	2	1,040.0	2	1,040.0			
Албан шаардлага	1	2,440.0	1	2,440.0			
Зөвлөмж	3	7,550.0	3	7,550.0			
Нийт дүн	6	11,030.0	6	11,030.0			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт үр дүнтэй зарцуулагдсан эсэх нь дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 80,863.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 60,753.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 20,110.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Тайлант оны санхүүгийн тайлангийн тэмдэглэл тайлбарыг ирүүлээгүй, цалингийн зардлыг дутуу тайлагнасан, өмнөх оны орлогыг зөрүүтэй тайлагнасан, мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус худалдан авсан зардлыг тайлагнаагүй зэрэг алдааг нягталж, холбогдох дансанд залруулж тайлагнуулав.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

5 байгууллагын 20,110.8 мянган төгрөгийн өр төлбөр тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй, автомашины өглөгийг дутуу бүртгэсэн, ХХОАТ-ын өр төлбөрийг илүү тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг мөрдөж ажиллаагүй, аудитын оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй 5 байгууллагын тооцоог хийж, баталгаажуулан, 2022 оны 06 сарын 25-ны дотор залруулж тайлагнах.

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Авто тээврийн хэрэгслийг байгууллагын хөрөнгөд бүртгэсэн хэдий ч өмчлөгчөөр тус өрхийн эрүүл мэндийн төвийн дарга бүртгүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”; аймгийн Засаг дарга, ЭМГ, ЭМДХ-тэй байгуулсан гүйцэтгэлийн гэрээний 9 дүгээр зүйлийн 9.3-т “төв нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг зохих байгууллагын зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдийн эзэмшил, ашиглалтад шилжүүлэхийг хориглоно” гэж заасныг мөрдөж ажиллаагүй, аудитын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Авто тээврийн хэрэгслийн өмчлөгчийг Нийцэл ӨЭМТ ЗГБХН-д 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор шилжүүлж, баталгаажуулах.

3. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлдэггүй, эмнэлгийн тусламж үйлчилгээнд хяналт хийдэг бөгөөд нөхөрлөлийн гишүүдийн хурал үр дүнгүй болдог, удирдлагад эрх мэдэл төвлөрсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”; 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно” гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлж, хариуцлагыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв	6	80,863.9	3	60,753.0					3	20,110.9